



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын
2019 оны 9 дүгээр сарын 26 өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**СУУРЬ БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ХЭЛ, ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ,
МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ФИЗИК БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ,
ТҮҮХ, НИЙГЭМ СУДЛАЛ, ДҮРСЛЭХ УРЛАГ, ХӨГЖИМ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИ,
БИЕИЙН ТАМИР, АНГЛИ ХЭЛ, ОРОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН САЙЖРУУЛСАН
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Суурь боловсрол VI-IX анги)

Улаанбаатар
2019



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
НИЙГЭМ СУДЛАЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**
(Суурь боловсрол ҮII-IX анги)

Улаанбаатар
2019

Нийгэм судлалын сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн гишүүд

О.Пүрэв	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Sc.D
С.Түмэндэлгэр	Монгол Улсын Боловсролын их сургууль, социологч багш, Ph.D
Ч.Гажиддулам	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, магистр
Р.Дарьхүү	Монгол Улсын их сургууль, философийн багш, Ph.D
Н.Мягмарцоож	Монгол Улсын Боловсролын их сургууль, улс төр судлалын багш, Ph.D
Ц.Сэлэнгэ	Монгол Улсын Боловсролын их сургууль, эдийн засгийн багш, Ph.D
Б.Батсүх	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн
А.Баярбаатар	Хэрэгжилтийн багийн гишүүн

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

О.Пүрэв	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Sc.D, профессор
С.Түмэндэлгэр	МУБИС-ийн багш, Ph.D., дэд профессор
Д.Пунцагсүрэн	Боловсролын хүрээлэн, секторын эрхлэгч, магистр
Ч.Гажиддулам	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, магистр

Хянан тохиолдуулсан (2019)

О.Пүрэв	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Sc.D, профессор, МУ-ын гавьяат багш
---------	-------------------------------------------------------------------------------------------------

НИЙГЭМ СУДЛАЛ

ҮИ-IX АНГИ

Удиртгал

Энэхү суралцахуйн удирдамж нь ерөнхий боловсролын нийгэм судлалын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үлгэрчилсэн төлөвлөлт юм.

Тус суралцахуйн удирдамжид ҮИ-IX ангийн нийгэм судлалын сургалтын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэхийг суралцахуйн зорилт, суралцахуйн үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүн, багшид зөвлөмж гэсэн хэсэгтэйгээр төлөвлөн боловсруулсан бөгөөд сурагч болон багшид суралцахуй хийгээд багшлахуйгаа төлөвлөхөд дэмжлэг, туслалцаа болно.

Мөн бүлэг бүрийн суралцахуйн зорилтуудыг агуулгыг нь нягтруулах, цомхотгох, гүйцэтгэлийг нь үнэлэхэд дөхөм болгох үүднээс суралцахуйн зорилт бүрийг жишээ нь, 7 дугаар ангийн 1 дүгээр сэдвийн 1 дүгээр суралцахуйн зорилтыг 7.1а., 2 дугаар суралцахуйн зорилтыг 7.1б. гэх мэт кодолсон. Кодын 7 нь ангийн дугаар, бусад нь суралцахуйн зорилтын дугаар юм.

Суралцахуйн зорилт бүрийн хүрээнд суралцахуйн үйл ажиллагааг санал болгосон нь жишиг гэдгийг анхаарч, багш нар өөрсдөө, сурагчдынхаа хэрэгцээ, туршлага, чадвар, хандлагын түвшинг харгалзан бүтээлчээр хөгжүүлэх боломжтой юм.

VII АНГИ

ХУВЬ ХҮН БА НИЙГЭМ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
7.1а. Сурагч анхдагч бүлгийн гишүүн гэдгийн үндэслэлийг баримтаар тайлбарлах	<ul style="list-style-type: none">- Өөрийн харьяалагдаж буй бүлгүүдийг нэрлэнэ.- Нэрлэсэн бүлгийн онцлог, ялгаатай байдлыг тодорхойлж, хэрхэн ангилж болох талаар зураглал хийнэ.- Гэр бүл, анги хамт олны бүтцийг зураглан нийтлэг, ялгааг тодруулна.- Гэр бүл, анги хамт олны дунд гарч буй харилцааны ялгаатай хэлбэрүүдийг танилцуулна.	Мягмарцоож. Н ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ., Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VII-IX . Багшийн ном УБ.,
7.1б. Байгууллагыг судлах замаар хоёрдогч бүлгийн тухай мэдэж, өөрт нь ямар нөлөө үзүүлж байгааг жишээгээр танилцуулах	<ul style="list-style-type: none">- Байгууллага гэж юу болох, хоёрдогч бүлэг, анхдагч бүлгээс ямар ялгаатай байгааг тайлбарлана.- Сургуулийн бүтцийг тодорхойлж, зураглана.- Сурагчийн байр суурь, үүргийг бусад бүлгийн байр суурь, үүрэгтэй харьцуулан хэлэлцэнэ.- Спорт, урлаг, дугуйланд хичээллэх, хичээлээ давтах, тоглоход нэгдэж буй бүлгүүд өөрт чинь болон бусад бүлэгт хэрхэн нөлөөлж байгаа талаар ангидаа танилцуулна.	
7.1в. Анхдагч, хоёрдогч бүлгийн орчинд зөрчил юунаас үүсдэг болох, зөрчлийг зохистойгоор шийдвэрлэх аргуудыг нэрлэх	<ul style="list-style-type: none">- Бусадтай харилцах үед зөрчил яагаад үүсдэг талаарх жишээ тохиолдлыг шинжилж, шалтгааныг ярилцана.- Бусадтай сөрөг харилцааас урьдчилан сэргийлж болох арга замуудын талаар жишээ гаргана.	

	- Бусадтай зүй зохистой харилцах талаар зөвлөмж бичиж, танилцуулна.	
Багшид зөвлөмж:		
<ul style="list-style-type: none"> - Агуулгын хувьд бүлэг, анхдагч болон хоёрдогч бүлэг, бүлгийн хувь хүнд үзүүлэх нөлөө, бүлгийн бүтэц, онцлогийн талаарх мэдлэг, ойлголтыг өөрсдийн ойр хүрээлж буй бүлгийн жишээ, баримтад тулгуурлан эзэмшүүлэхийн зэрэгцээ хичээлүүдийг багцлан судлахад анхаарна уу. - Сурагч байгууллагыг судлах замаар хоёрдогч бүлгийн гишүүн гэдгээ мэдрэх, ойлгох, мөн бусдыг хүндэтгэн харилцахад суралцахад анхаарна уу. - Агуулгын хувьд бүлэг болон харилцааны зөрчлийн талаар судлах тул сургалтыг багаар зохион байгуулах боломжтой. - Сургууль гэсэн жишээн дээр ажиллахдаа: сургуулийн зорилго юу вэ? жишээлбэл, өөрийн сургуулийн эрхэм зорилго юу болох, байгууллагын гишүүд нь ямар байр суурь эзэлж, ямар үүрэг гүйцэтгэдэг, өөр хоорондоо хэрхэн харилцаж байгаа талаар ярилцлага өрнүүлэн, зураглал үйлдэхэд анхаарна.. - Эндээс хоёрдогч бүлэг, байгууллага гэж юу болохыг өөрсдөө тодорхойлоход нь туслаарай. - Мөн байгууллагыг институттэй хольж буруу ташаа тайлбарласан сурах бичиг, гарын авлага хэрэглэхээс татгалзаарай. - Сурагч анхдагч бүлгийн гишүүн гэдгээ мэдрэх, ойлгох, үйлдэх нь түүний аливаа бүлгийн үйл ажиллагаан дахь идвэх, оролцоогоор илрэх тул багш сурагчийн энэ чадварыг илрүүлэн хөгжүүлэх, үнэлэхэд анхаарна уу. 		

ХУВЬ ХҮН БА СОЁЛ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
7.2а. Өөрийгөө соёлыг бүтээгч хийгээд соёлын нөлөөнд амьдардаг талаар жишээгээр тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Соёл нь хүн бүрд болон хувь хүний төлөвшилд хэрхэн нөлөөлөхийг жишээгээр илэрхийлэн тайлбарлана /харилцаа, хувцаслалт, итгэл үнэмшил, үнэт зүйлс гэх мэт/ - Хувь хүн соёлыг бүтээж байгаа тухай эхийг уншиж, а. Оюуны соёл б.Эдийн соёл в.Бусад үнэт зүйл гэсэн шалгууруудаар задлан шинжилж, дүгнэт өгнө. - Хүн соёлын нөлөөнд хэрхэн амьдарч буй талаар “хэл”-ний жишээ, баримтаар хэлэлцэнэ. 	<p>Мягмарцоож. Н ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,</p> <p>Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VII-IX . Багшийн ном УБ.,</p>
7.2б. Бүлгийн түвшинд бусдын соёлыг ойлгодог, хүндэтгэдэг эрмэлзэлтэй болохоо жишээгээр илэрхийлэх	<ul style="list-style-type: none"> - Өөрийн гэр бүлийн соёл нь бусад гэр бүлийн соёлоос ямар ялгаатай талаар мэдээлэл бэлтгэж, танилцуулна. - Гэр бүлийн соёлын ялгаатай орчин байдгийг нотолгоо дэвшүүлэн хэлэлцэнэ. - Сургуулийн орчинд бусдын соёлыг хэрхэн ойлгож, хүндэтгэх талаар зураглал гаргана. 	
Багшид зөвлөмж:		
<ul style="list-style-type: none"> • Соёл бол хүнийг төлөвшүүлэх чухал зүйл гэдгийг гэдгийг сурагчдад ойлгуулах, ухамсарлуулах • Соёл гэж юу вэ?, яагаад чухал болох талаар сурагчдын өмнөх мэдлэг, төсөөлөл дээр тулгуурлан ярилцах. Голлон харилцааны соёлын талаар ярилцаж, судлуулна уу. • Соёл гэж юу вэ?, яагаад чухал болох талаар сурагчдын өмнөх мэдлэг, төсөөлөлд тулгуурлах, сурагчид өөрийнхөө болон гэр бүлийнхээ үнэт зүйл, өв соёлын тухай танилцуулах, ярилцах замаар би өөрөө соёлыг бүтээгч түүнчлэн соёлынхоо орчинд аж төрж, амьдардаг гэдгээ ухааран ойлгоход сурагчдын суралцах үйлийг чиглүүлэн хичээлээ төлөвлөөрөй. • Мөн соёл нь тодорхой нийгэм, бүлэг хүмүүсийг үйлдэх, мэдрэх, бодох загварт суралцуулдаг нэг үеэс нөгөө үед уламжлагдаж байдаг үнэт зүйл гэсэн ойлголтыг эзэмшүүлэхэд анхаарна уу. • Сурах бичиг, агуулгад тохирох оновчтой эх, жишээг сонгон соёлын нөлөөний талаар сурагчдад 		

эргэцүүлэн бодох, харилцан ярилцаж дүгнэлт, шийдэл гаргах боломжийг хичээл төлөвлөхдөө анхаарна уу.

- Сургуулийн орчинд бусдын соёлыг хэрхэн ойлгож, хүндэтгэлтэй хандаж буйг ажиглалт, үйлдэл, дүрийн тоглолт, оролцоогоор илрүүлэх зорилгоор ажиглалтын хуудас, ярилцлагын тэмдэглэл, рубрик, өөрийн үнэлгээний хуудсыг ашиглах боломжтой.
- Бүлэг сэдвээр хичээлийг төлөвлөөрэй.

ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
7.3а. Өрхийн түвшинд судлан, хэрэгцээ хязгааргүй, нөөц хязгаарлагдмал болохыг тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Тухайн сарынхаа өрх гэрийнхээ хэрэгцээ, орлого, зарлагыг тооцоолно. - Хэрэгцээ хязгааргүй, түүнийг хангах нөөц баялаг нь хязгаарлагдмал шинжтэй болохыг өөрийн амьдралын жишээ, баримтаар үндэслэн нотолгоо гаргана. - Өөрийн өрхийн орлогын эх үүсвэрүүд, түүнийг юунд, хэрхэн, яаж зарцуулдаг, зардлаа хэмнэх, хуримтлалтай болох талаар зөвлөмж бичиж танилцуулна. 	<p>Мягмарцоож. Н ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,</p> <p>Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VII-IX . Багшийн ном УБ.,</p>
7.3б. Өрхийн хөдөлмөрийн хуваарь дахь өөрийн оролцоог жишээгээр тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Өрх, гэр бүлийн гишүүдийн ажил, хөдөлмөрийг ажиглаж, өөрөө болон аав, ээж, ах, эгч, дүү ямар ажил хийж байгааг тэмдэглэнэ. - Үүнийхээ дүнд хөдөлмөрийн хуваарийг гэр бүлийн гишүүн бүрээр гаргаж, хэлэлцэнэ. 	
7.3в. Сургуулийн жишээгээр зардлыг ангилж, тооцоолол хийн, зардлыг хэмнэхэд оруулах санаачилгаа үнэлэх	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн зардлыг сургалтын орчин, цахилгаан, ус, дулаан г.м-ээр ангилна. - Сургуулийн зардлын төрөл, зарцуулалтыг ихээс бага руу нь эрэмбэлж, тус бүрийн хэмжээг тооцоолно. - Сургуулийн зардлыг хэмнэх талаар багаар хамтран ажиллаж, уриалга гаргана. 	

Багшид зөвлөмж:

- Өрхийн амьжиргааны наад захын хэрэгцээг ялгуулж мөнгөтэй харьцах, барааны тэмдэгтүүдэд үндэслэн худалдаа хийх соёл, чадвар эзэмшүүлэхэд багш чиглүүлнэ.
- Сурагчдад бага наснаас нь мөнгө хуримтлуулах сонирхлыг нь төрүүлэх зорилгоор “онц хэрэгцээгүй, үр ашиггүй зардлыг бууруулснаар хэдэн төгрөг хэмнэж болох байсан, түүнийгээ банкинд хадгалуулсан бол сургууль төгсөхөд хэд болж өсөх вэ?, эсвэл хүсэж байгаа зүйлээ худалдан авахад тань хэдэн төгрөг хэрэгтэй вэ? /жишээ нь англи хэлний толь бичиг худалдан авахад/, түүнийгээ саруудад хуваавал сард хэдэн төгрөг хадгалах хэрэгтэй вэ, энэ мөнгийг хэрхэн хуримтлуулж болох талаар тооцоо хийлгэх зэргээр бүтээлч үйл төлөвлөн хэрэгжүүлээрэй.
- Өрх, сургуулийн эдийн засагт хамаарах мэдээллийг урьдчилан сайтар бэлтгэсэн байхад анхаарна уу.
- Сурагчдын гүйцэтгэлд багшийн зүгээс явцын үнэлгээ, санал зөвлөмжийг өгнө. Эхлээд давуу талыг нь дурьдсаны дараагаар сул тал, сайжруулбал зохих санал, уншиж судлах эх сурвалжийг санал болгох зэрэгт багш та анхаарлаа хандуулаарай.

ХҮНИЙ ЭРХ БА ХУУЛЬ

Суралцахуйн зорилт	Сурахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
7.4а. Хүүхдэд чиглэсэн хайр халамж, тусламж,	- Хүүхэд хөгжих, оролцох, хамгаалуулах, эсэн мэнд амьдрах эрхүүдтэй холбогдох жишээ,	Мягмарцоож. Н ба бусад (2017) Нийгэм судлал-

үйлчилгээг эргэцүүлэн ярилцаж, хүүхдийн эрхийн тухай ойлголтоо баяжуулах	тохиолдлыг шинжилнэ. - Эрхээ эдэлж чадахгүй байгаа бодит жишээ баримтыг судалж түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг нотолгоо гарган хэлэлцэнэ.	VII анги. Сурах бичиг УБ., Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VII-IX . Багшийн ном УБ.,
7.4б. Хүүхдийн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхгүй байхын сөрөг үр дагаврыг тодорхойлж, өөрийн эрх, үүргийн хэрэгжилтийг үнэлэх	- Хүүхдийн эрх зөрчигдөх, үүргээ биелүүлэхгүй байх болон хариуцлагагүй байдлын талаар жишээ тохиолдол шинжилнэ. - Гэртээ болон ангидаа өөрийн эрхийн хэрэгжилт ямар байгаа талаар үнэлгээ хийнэ. - Эрх, үүрэг, хариуцлагын холбоо хамаарал бүхий бодит жишээ гарган тайлбарлана.	
7.4в. Сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар судалж, дүрэм, журам, хууль нь хүний эрхийг хамгаалах арга, хэрэгсэл болох тухай дүгнэх	- Хүүхдийн эрхийг байгууллага (сургууль), холбогдох хүмүүс (захирал, багш гэх мэт) хэрхэн хангаж, хамгаалж байдаг тухай бүдүүвч зураглал хийнэ. - Хүүхдүүд сургуулийн орчинд баримтлах дэг, дүрэм журам, дагаж мөрдөх ёстой хуулийг хүндэтгэх, мөрдөх, мөрдөөгүйгээс гарах үр дагаврын талаар хэлэлцэнэ.	
Багшид зөвлөмж:		
<ul style="list-style-type: none"> • Багш хичээлээ төлөвлөж, хөтлөн явуулахдаа хүүхдүүд эрхтэй гэдгээ мэдэж, ойлгохоос гадна эдгээр эрхээ эдэлж байгаагаа үнэлж, хүндэтгэлтэй хандаж сурахад нь чиглүүлнэ. • Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд сурагчдын өдөр тутмын амьдралтай холбон тайлбарлах, жишээ гаргуулах, бусадтай хамтран ярилцах боломжийг бүрдүүлээрэй. • Тохиолдол шинжлэх сургалтын арга зүйн дагуу сургалтыг сайтар төлөвлөөрэй. • Сургууль, ангийн мөрдөж буй дүрэм, журмыг сургалтад гол кейс болгон ашиглах • Сурагчдын судлан шинжилсэнийхээ үр дүнд шинэ мэдлэгийг өөрөө бүтээх үйл ажиллагааны нарийвчилсан удирдамжуудыг урьдчилан бэлтгэж, чиглүүлэн тусална. Ингэхдээ чиглүүлэх асуултуудыг оновчлон төлөвлөсөн байна. • Судалж буй сэдвийн хүрээнд дэх үнэт зүйлийг өөрийн итгэл үнэмшил болгож, түүнийхээ дагуу үйл, үйлдэл хийж буй байдлыг ажлын хуудас, рубрик, ажиглалтаар үнэлэх боломжтой. 		

НИЙТИЙН УДИРДЛАГА

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
7.5а. Анги, хамт олны шийдвэрийг судлан, хамтын удирдлага, шийдвэр, оролцооны тухай ойлгох	- Анги, хамт олны хэлэлцэж буй хамтын, удирдлага, шийдвэрийн талаар жишээ, тохиолдол шинжилнэ. - Хамтын удирдлага, шийдвэр дэх хувь хүн (Би)-ий үүрэг, оролцооны талаар үндэслэл гарган бусдад тайлбарлана.	Мягмарцоож. Н ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,
7.5б. Сургуулийнхаа сурагчдын өөрөө удирдах байгууллагын талаар судалж, уг байгууллагын зорилго, үүргийн талаар нотлон тайлбарлах	- Сургуулийнхаа СӨУЗ, клубээс зохион байгуулсан үйл ажиллагааны талаар танилцуулна. - Сургуулийнхаа хүүхдийн өөрөө удирдах байгууллага, удирдлагын бусад байгууллагын зорилго, үүргийг харьцуулна. - Сургуулийнхаа хүүхдийн өөрөө удирдах байгууллага, удирдлагын бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцох хувилбаруудыг дэвшүүлнэ.	Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VII-IX . Багшийн ном УБ.,
Багшид зөвлөмж:		
- Агуулгын хувьд: Хамтын удирдлагын талаар анги, сургуулийн СӨУБ-ын жишээгээр ойлгох, өөрийн оролцооог чухалчлахад чиглүүлнэ.		

<ul style="list-style-type: none"> - Асуудал, нөхцөл өгч хамтын шийдвэр гаргуулах зэргээр асуудал шийдвэрлэх арга зүйн дагуу хичээлийг удирдахаар төлөвлөөрэй. - Сургуулийнхаа СӨУЗ-ийн үйл ажиллагааг судлах - Асуулт хариулт, хэлэлцүүлэг, тохиолдол шинжлэх зэрэг оролцооны олон аргыг хэрэглэж болох бөгөөд хичээлд зочин урьж оролцуулж ч болно. - Бүлгээр ажиллахад сурагч бүрийн оролцоо чухал бөгөөд тэд зөвхөн академик мэдлэг аваад зогсохгүй бусадтай зөв харилцах чадвар, хандлагыг нь хөгжүүлэхэд суралцахуйг хөтөлнө үү.

VIII АНГИ

ХУВЬ ХҮН БА НИЙГЭМ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
8.1а. Орон нутгийн байгууллагууд, бусад бүлгүүдийн уялдаа холбоог зураглаж, хувь хүний амьдралд үзүүлж буй нөлөөллийг жишээгээр тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн нийгэм-хамт олны бүлгүүдийн (гэр бүл, төрөл садан, орц, хот айл г.м) чиг үүргийн уялдаа холбоог хүснэгтээр үзүүлнэ. - Хувь хүний өдөр тутмын амьдралд орон нутгийн байгууллага, бүлэг ямар нөлөө үзүүлж байгаа талаар жишээ, баримт гарган хэлэлцэнэ. 	<p>Алтангэрэл.Ч ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,</p> <p>Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VII-IX . Багшийн ном УБ.,</p>
8.1б. Орон нутгийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, тэдгээр нь хүмүүсийн байр суурь, үүрэг, соёлын ялгаанаас хэрхэн хамаарч байгааг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг ядуурал, хог хаягдал, байгаль орчны доройтол, цөлжилт г.м. эер жагсаан бичнэ. - Асуудлууд нь байр суурь, соёлын хувьд ялгаатай ямар ямар хүмүүстэй хэрхэн холбогдож байгаа, хэнд нь асуудал, хэнд нь асуудал биш, хэн нь хэнийхээ эрх ашгийг хөндөж байна гэх мэтийн талаар зураглан ярилцана. 	
8.1в. Зөрчил нь байр суурь, соёлын ялгаанаас үүдэлтэй болохыг мэдэж, зөрчлийн эерэг, сөрөг талуудыг хэлэлцэх, үл ойлголцол, зөрчлөөс сэргийлэх арга замуудыг нэрлэх	<ul style="list-style-type: none"> - Нэг орон нутагт амьдарч буй хүмүүс өөр хоорондоо хэрхэн харилцдаг, харилцаанд зөрчил хэрхэн үүсдэг талаар тайлбарлана. - Зөрчлийг хэрхэн шийдвэрлэх нь зүйтэй вэ? гэсэн асуудлын хүрээнд тохиолдол шинжилж, зөрчлөөс сэргийлэх арга замуудыг хэлэлцэнэ. 	
<p>Багшид зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Нэг ээлжит хичээлээр асуудал шийдвэрлэж, тохиолдол шинжлэх бус бүлэг сэдвийн хүрээнд хэрэгжүүлэхдээ тохиолдол шинжлэх, асуудал шийдвэрлэх арга зүйн аль нэгээр зохион байгуулбал илүү үр дүнтэй. • Сурах бичгээ сайтар судалж, ашиглахын зэрэгцээ орон нутгийн жишээ, тохиолдлыг судлан шинжлэхэд суралцахуйг төлөвлөн хэрэгжүүлнэ үү. • Судалж буй сэдвийн хүрээнд үнэт зүйлийг өөрийн итгэл үнэмшил болгож, түүнийхээ дагуу үйл, үйлдэл хийж буй байдлыг ажлын хуудас, рубрик, ажиглалтаар үнэлэх боломжтой. 		

ХУВЬ ХҮН БА СОЁЛ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
8.2а. Орон нутгийнхаа өв соёлын тухай мэдээлэлд тулгуурлан өвөрмөц байдлыг нь танилцуулж, бахархах эрмэлзлээ жишээгээр	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийнхаа соёлын үнэт зүйлсийг тодорхойлно. - Орон нутгийнхаа соёлын өвөрмөц байдлыг харуулсан жишээ, соёлын дурсгалт зүйлсийн жагсаалт, соёлын өвийн зураглал гаргаж, танилцуулна. 	Алтангэрэл.Ч ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,

илэрхийлэх		
8.2б. Хүн бусдын соёлыг ойлгох, хүндэтгэхийг илтгэх үйлдлийн төрлүүдийг нэрлэж, жишээ гаргах	<ul style="list-style-type: none"> - Соёл бол бусдын соёлыг хүндэтгэн харилцахад баримтлах хэм хэмжээ болох талаар нотолгоо гаргана. - Бусадтай харилцахдаа ихэвчлэн гаргадаг алдаа, түүний сөрөг үр дагаврыг хэлэлцэнэ. - Өөрийн болон бусдын алдааг засах талаар гаргасан төлөвлөгөөгөө танилцуулна. 	Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VII-IX . Багшийн ном УБ.,
8.2в. Орон нутаг дахь соёлын хожимдлын асуудлыг судлаж, асуудлыг шийдэхэд оруулах өөрийн хувь нэмрийг үндэслэн тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Соёлын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тайлбарлана. - Соёлын хожимдол түүний үр дагаврын талаар мэтгэлцээрэй. 	
Багшид зөвлөмж:		
<ul style="list-style-type: none"> • Жижиг сэдвүүд гэхээсээ бүлэг сэдвээр хичээлийг төлөвлөн “Хувь хүн ба нийгэм”, “Хүний эрх”, “Нийтийн удирдлага” бүлэг сэдвүүдтэй холбон асуудал, тохиолдол шинжлэх үйлийг хийлгээрэй. • Соёлын үнэ цэнийн тухай хэлэлцэх, ном, зураг, кино, бичлэг, жүжиг зэрэгт тулгуурлан ярилцах, мэдээлэл цуглуулах боломжийг сурагчдад олгоорой. • Орон нутгийнхаа өв соёлын тухай судлан, онцлог, өөрчлөлтийг таньж мэдэх, түүгээрээ бахархах, оролцох эрмэлзэлтэй болоход багш таны хичээл төлөвлөлт, хичээл, сургалтаар хийлгэх үйл ажиллагаанууд чиглэнэ. • Хүний амьдралд нийгмийн соёлоос өөрөөр хэлбэл, хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаанаас суралцах нь чухал болохыг сурагч эрэл хайгуул хийж, дүгнэлт гаргасны үндсэн дээр зөв ойлголт эзэмших, үйлдлээрээ илтгэн харуулах хүсэл эрмэлзэлтэй болох, сурагч орон нутгийнхаа болон үндэсний соёлын өвийн талаар түүхэн баримтад тулгуурлан сурах арга барилаа ашиглан энэ асуудлаар тодорхой ойлголт, итгэл үнэмшилтэй болоход нь чиглүүлнэ. 		

ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
8.3а. Орон нутгийнхаа ААН-ийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн тухай ойлгож, танилцуулах	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийнхаа бизнесийн байгууллагуудаас нэгийг сонгон авч тэдгээр нь ямар, ямар нөөцүүдийг ашиглан, ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болохыг нэрлэх - Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарах зардал, олох орлого, ашгийн хэмжээг тооцоолно. - Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бүдүүвч зураглал хийж хэлэлцэнэ. 	Алтангэрэл.Ч ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,
8.3б. Орон нутгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг судлаж, зах зээлийн талаар ойлголттой болох	<ul style="list-style-type: none"> - Зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнийн талаар мэдээлэл цуглуулж, график байгуулан тайлбарлана. - Орон нутгийн төсөв, бүтээгдэхүүний зах зээлийг судлах замаар зах зээлийн үндсэн ойлголтуудын тайлбар толь хийнэ. 	Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VI-IX . Багшийн ном УБ.,
8.3в. Жижиг бизнес эрхлэх зураглал гаргах, танилцуулах	<ul style="list-style-type: none"> - Жижиг үйлдвэрлэл, бизнес эрхлэх төслийн санаа, зураглал гаргаж боловсруулна. - Жижиг үйлдвэрлэл төслийн санаа, зураглалаа хэрэгжүүлснээр олох орлого, зардал, ашгийн хэмжээ, эрсдэлийг урьдчилан тооцоолно. 	
Багшид зөвлөмж:		

- Орон нутгийн төсөвт шинжилгээ хийж бүтцийн болон динамик үзүүлэлтүүдийг тодорхойлж сурах, зөв хэрэглэгч байх арга ухаанд суралцахад нь үйл ажиллагаа, суралцахуйг чиглүүлэх, аливаа өмч, хөрөнгийг хайрлах, ариг гамтай хэрэглэх дадал зан үйлд суралцахад нь анхаарна.
- Асуудлыг аль болохоор сурагчид өөрсдөө судалж, дүгнэлт хийн ярилцах боломжийг бүрдүүлэхэд чиглүүлнэ. Энэ зорилгоор орон нутгийн төсвийн талаар танилцуулах материал, эдийн засгийн хөгжлийн байгаль, экологит үзүүлж байгаа эерэг болон сөрөг талуудыг харуулсан дүүрс бичлэг эсвэл фото зургийн цомог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнийн талаар судалгаа хийх арга зүй, зөвлөмж, өрх, сургууль болон орон нутгийн төсвийн адил болон ялгаатай талуудыг тодорхойлон бичих ажлын хуудас, компьютерийн хэрэглээний программуудыг сургалтын хэрэглэгдэхүүнээр ашиглаж болно.
- Үүний дараа орон нутгийн зах зээлийг судалж, улмаар жижиг бизнесийн төлөвлөлт хийхээр хичээлүүдийг залгамжтайгаар төлөвлөөрэй.
- Орон нутгийнхаа бизнесийн байгууллагуудаас нэгийг сонгон авч, түүнийг судлахад бэлтгээрэй.

ХҮНИЙ ЭРХ БА ХУУЛЬ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
8.4а. Хүний эрх, эрх чөлөөний түүхэн хөгжлийн эх сурвалжийг судлан, хүний эрхийн заяагдмал мөн чанарын үндэслэлүүдийг тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Хүний эрх, эрх чөлөө, хүний эрхийн түүхэн хөгжлийн талаарх түүхэн баримт, эх сурвалжийг шинжилж, хүний эрхийн хөгжлийн тухай зураглал гаргана. - Хүний эрхийн жам ёсны мөн чанар, түүний үндсэн зарчмын талаар хэлэлцэж, мэдээлэл бэлтгэнэ. 	Алтангэрэл.Ч ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,
8.4б. Хүний эрхийн зарчмууд, иргэн, байгууллага, төр нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах талаар хариуцлага хүлээдэгийг үндэслэн тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Хүн бүр адил тэгш эрхтэй амьдарч чадахгүй байгаа талаарх жишээ, тохиолдол шинжилнэ. - Соёлын өөр, өөр орчны олон янзын хэв маягийг харуулсан зураг ашиглан хүний эрхийн зарчмуудтай ямар уялдаа, холбоотойг тайлбарлана. 	Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VI-IX . Багшийн ном УБ.,
8.4в. Орон нутгийн жишээгээр хүний эрхийн зөрчлийг ялган таньж, дүрэм журам, хуулийн хүрээнд хүний эрхийг хэрхэн хамгаалах талаар дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн жишээн дээр хүний эрхийн зөрчлийг харуулсан тайлбар бүхий зургуудыг ажиглаж, ярилцана. - Хүний эрхийн зөрчлийг ангилж, хүний ямар эрх хэрхэн зөрчигдсөн болох талаар өөрсдийн саналыг боловсруулж, тайлбарлана. - Тохиолдол шинжлэн хүний эрхийн зөрчлийг хуулийн хүрээнд хэрхэн шийдвэрлэх арга замууд байгаа талаар зөвлөмж боловсруулж ангидаа танилцуулна. 	
Багшид зөвлөмж:		
<ul style="list-style-type: none"> - Багш хичээлээ төлөвлөж, хөтлөн явуулахдаа хүний эрхийн түүхэн хөгжил, эрх, эрх чөлөө нь хүн төрөлхтөнд ямар их үнэ цэнээр олдсон талаар түүхэн баримтад тулгуурлан хүний эрх эрхэм үнэт зүйл болохыг өөрсдөөр нь ойлгуулахад чиглүүлнэ. - Хүний эрхийн түүхэн хөгжлийг харуулахуйц товч, тодорхой, ойлгомжтой түүхэн баримт мэдээлэл, зурагт үзүүлэн бэлтгэн хэрэглэж болно. - Монгол улсын Үндсэн хууль, 2-р бүлгийг ашиглана. - Нэг кейсийг тойруулан судлахаар төлөвлөөрэй. 		

НИЙТИЙН УДИРДЛАГА

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
8.5а. Орон нутгийн түвшинд бодлого,	- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын онцлог, үйл ажиллагааны талаар ярилцана.	Алтангэрэл.Ч ба бусад (2017) Нийгэм судлал-

<p>шийдвэр хэрхэн гардаг, түүнийг хэрхэн хэрэгжүүлэхийг судлаж, нийтийн удирдлагын тухай ойлголтоо гүнзгийрүүлэх</p>	<p>- Иргэдийн Нийтийн Хурлын талаар өөрсдийн цуглуулсан мэдээлэл /Иргэдийн Нийтийн Хуралд хэн оролцох эрхтэй вэ? Иргэдийн Нийтийн Хурлаар ямар асуудлыг шийддэг вэ?/-ийн хүрээнд хамтран хэлэлцэнэ.</p>	<p>VII анги. Сурах бичиг УБ., Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VI-IX . Багшийн ном УБ.,</p>
<p>8.5б. Орон нутагт хүүхдийн талаар гаргасан шийдвэрийг судлан, шийдвэрт тусгах санал боловсруулах</p>	<p>- Өөрийн орон нутгийн төрийн байгууллага, албан тушаалтнаас хүүхэдтэй холбоотой тэдний эрх ашгийг хамгаалсан ямар шийдвэр гаргасан талаар зочинтой ярилцлага хийнэ.</p> <p>- Орон нутгийн хүрээнд хүүхэдтэй холбоотой цаашид гарах шийдвэрт хэрхэн оролцох талаар саналаа бичиж, хүргүүлнэ.</p>	
<p>Багшид зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Баг, хорооны ИНХ, сум, дүүргийн ИТХ-тай очиж танилцах, эрх бүхий албан тушаалтантай ярилцах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөөрэй. • Иргэдийн Нийтийн Хурал, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын талаарх нэмэлт мэдээлэл бэлтгэн ашиглана. • Сурагчдын оролцоонд тулгуурласан идэвхтэй сургалтын арга зүйгээр хичээлийг төлөвлөн зохион байгуулах боломжтой. Тухайлбал, ИТХ-ын төлөөллийг хичээлдээ урьж оролцуулан ярилцах, Сурвалжлага /судалгаа/ хийх даалгавар: Иргэдийн Нийтийн Хурлын талаар танай гэр бүлийнхэн хэр мэддэг вэ? Үйл ажиллагаанд нь оролцдог уу? Ямар эрх мэдэлтэй байгууллага вэ? гэдгийг судлуулах, хурлын үйл ажиллагааг очиж эсвэл бичлэгээр үзэх, ажиглах нь үр дүнтэйг анхаарна. • Баримт бичиг, аливаа шийдвэрийг сонгохдоо сурагчдад ойлгомжтой, энгийн, тэдний эрх ашигтай шууд холбоотой байхыг анхаарч, энгийн аргачлалыг боловсруулан хэрэглүүлнэ. 		

IX АНГИ

ХУВЬ ХҮН БА НИЙГЭМ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>9.1а. Харилцан үйлдэл дэх бэлгэ тэмдгийн (утгын) тогтолцоо хэрхэн бүрэлддэг, өөрчлөгддөг болохыг хүмүүс хоорондын харилцан үйлдлийн жишээгээр тайлбарлах</p>	<p>- Хүмүүсийн харилцаа нь мэдээлэл солилцох, харилцах олон арга хэлбэрийг ашигладаг болохыг жишээ баримтаар нотолно.</p> <p>- Харилцан үйлдлийн хэлбэрүүдийн жишээ гарган тайлбарлана.</p>	<p>Нэмэхжаргал.Т ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,</p> <p>Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VI-IX . Багшийн ном УБ.,</p>
<p>9.1б. Хүмүүс хоорондын үгэн болон үгэн бус харилцаанд субъектийн байр суурь, үүргийн ялгаа хэрхэн илэрч байгаа талаар дүгнэн, бусадтай дүнтэй харилцах арга замуудыг танилцуулах</p>	<p>- Жишээ, тохиолдол шинжлэх замаар үгэн ба үгэн бус харилцаа, байр суурийн ялгаа ямар байгаа талаар ярилцана.</p> <p>- Бусадтай үр дүнтэй харилцах нэг арга замыг хэрэглэх талаар багаар хамтран ажиллаж, үр дүнгээ ангидаа танилцуулна.</p>	
<p>9.1в. Хүмүүсийн хоорондын үл ойлголцол, маргааны шалтгаан, үр дагаврыг шинжлэн, шийдвэрлэх</p>	<p>- Хүмүүсийн хооронд үүсч буй үл ойлголцол, маргаан гарч буй шалтгааныг нэрлэнэ.</p> <p>- Тохиолдол шинжлэн зөрчлийг үүсгэгч хүчин зүйлсийг тодорхойлж, түүнээс гарах, зайлсхийх үр дүнтэй хувилбаруудын талаар</p>	

аргуудын талаар зөвлөмж гаргах	санал, зөвлөмж боловсруулна.	
Багшид зөвлөмж: <ul style="list-style-type: none"> Харилцан үйлдэл, үгэн ба үгэн бус харилцаа зэрэг үндсэн ойлголтуудыг ойлголтын зураглалд тулгуурлан эзэмшүүлэхэд анхаарна. Харилцан үйлдэл, харилцаа, зөрчлийг нийгмийн бүтэц, байр суурь, үүрэгтэй нь холбон судлахад хөтлөнө үү. 		

ХУВЬ ХҮН БА СОЁЛ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
9.2а. Өөрийн улс орон, үндэстний соёлын өвөрмөц байдал, ижилслийг бусад улс орон, үндэстний соёлын өвөрмөц байдалтай харьцуулж, жишээ баримтаар танилцуулах	<ul style="list-style-type: none"> Соёл олон төрөл бөгөөд тэдгээрийн хоорондын холбоо хамаарал, нөлөөлөл, өөрчлөлтийг илрүүлэх таамаглал дэвшүүлнэ Олон соёлын нөхцөлд зохицон амьдрах арга ухаанаас кино, ном зохиолоор дамжуулан мэдээлэл цуглуулна. Өөрийн улс, үндэстний бусад улс, үндэстнээс ялгарах ёс заншил, өв уламжлалын утга учир, ач холбогдлыг тайлбарлана. 	<p>Нэмэхжаргал.Т ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,</p> <p>Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VI-IX . Багшийн ном УБ.,</p> <p>Монгол үндэстний соёлын биет бус өвийн ховор хосгүй төрөл зүйлс” С.Юндэнбат нарын бүтээл,</p> <p>Монголчуудын соёлын үнэт зүйл, үзмэрийн тухай зураг, бодит жишээ, баримт, ажиллах тохиолдол, кино, түүхийн хичээлийн сургалтын хөтөлбөр, зөвлөмж, сурах бичгүүд</p>
9.2б. Соёл үнэт зүйлсийн тогтолцоо болохыг жишээ, эх сурвалжид тулгуурлан тодорхойлж, соёлын үүргийн ач холбогдлыг танилцуулах	<ul style="list-style-type: none"> Өөрийн үндэстний соёлын бусдын соёлоос ялгарах үнэт зүйл, өвөрмөц байдал, ижилсэл ойлголтыг тодорхойлно. Соёлын өвийг хүндэтгэн, дээдлэх шалтгаан, өвлөхийн ач холбогдлын талаар ангидаа илтгэл бэлтгэн танилцуулна. 	
Багшид зөвлөмж: <ul style="list-style-type: none"> Бүлэг сэдвээр хичээл төлөвлөх, асуудлыг шинжлэх судлахаар хичээлийг төлөвлөхдөө олон соёлын уулзварт хэрхэн, яаж ажиллаж, амьдрах арга ухаанаас суралцуулахад анхаарна. Сурагчдад ойлгомжтой, бодит амьдралаас сэдэвлэсэн жишээ, тохиолдол, соёлын үнэт зүйлс, соёлын өвийн ангиллын талаарх мэдээлэлтэй ажиллахдаа сурагч өөрөө дүгнэлт хийх боломжийг олгоорой. Сурагчдыг сэдэлжүүлэх, хамтран ярилцах зэрэгт чиглэсэн соёлын үнэт зүйлсийн талаарх тайлбар бүхий зурагт үзүүлэн, бид өөрсдөө соёлыг бүтээгч болох тухай товч, тодорхой, ойлгомжтой түүхэн баримт, мэдээлэл бэлтгэн хэрэглээрэй. Соёл бол үнэт зүйлсийн тогтолцоо болохыг ухааран ойлгож хүндэтгэх, дээдлэх, өвлөх үүргээ ухаарч ойлгох болон хүсэл эрмэлзлийг нь илрүүлэн үнэлэхэд өөрийн болон явцын үнэлгээг чиглүүлнэ үү. 		

ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
9.3а. Хөдөлмөрийн зах зээл, цалин хөлс, ажил мэргэжлийн эрэлтийн талаарх мэдээллийг шинжилж, тэдгээрийн	<ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнийн талаар мэдээлэл цуглуулна. Цалин хөлс, татвар, шимтгэлийн хэмжээг тооцоолно. Цалин хөлсний хэмжээнд нөлөөлөх хүчин 	<p>Нэмэхжаргал.Т ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ.,</p>

уялдаа холбоог тодорхойлон, нөлөөлөгч хүчин зүйлсийг тайлбарлах	зүйлсийн талаар таамаглал дэвшүүлж, шийдвэрлэнэ.	Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VI-IX . Багшийн ном УБ.,
9.3б. Ирээдүйд эзэмших мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлж, зорилго дэвшүүлэн, түүндээ хүрэх арга замыг зураглах	<ul style="list-style-type: none"> - Эрэлттэй мэргэжлийн жагсаалт гаргана. - Янз бүрийн мэргэжилд тавигдах шаардлагуудыг харьцуулна - Өөрийн авьяас, чадварыг тодорхойлж мэргэжлээ зөв сонгох шийдвэр гаргана. - Өөрийн давуу болон боломж, сул талаа тодорхойлж, тооцож хувийн төлөвлөлтийн зураглал гаргана. 	
9.3в. Мөнгө, банкны нийгэмд гүйцэтгэх үүрэг, мөнгөний худалдан авах чадварын талаар судлан, хуримтлалын ач холбогдол, арвижуулах арга замуудыг танилцуулах	<ul style="list-style-type: none"> - Мөнгөний бидний амьдралд гүйцэтгэх үүргийг тодорхойлно. - Хуримтлалын ач холбогдлыг тайлбарлана. - Хуримтлал бий болгох үр дүнтэй төлөвлөлт гарган хэлэлцэнэ. 	
<p>Багшид зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн зах зээл, цалин хөлс, ажил мэргэжлийн эрэлт, мөнгө, банк, мөнгөний худалдан авах чадвар зэрэг эдийн засгийн үндсэн ойлголтуудыг эзэмшихэд хөтлөөрэй. • Шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх арга зүйн дагуу бүлэг сэдвээр нь төлөвлөөрэй • Хөдөлмөр нь эдийн засгийн нөөц болох, ажилгүйдэл яагаад үүсдэг, хүн ажилгүй болохгүйн тулд юунд анхаарах ёстой, цалин ба хөдөлмөрийн бүтээмж нь хоорондоо нягт холбоотой байдаг, цалингаас яагаад татвар, шимтгэлүүд авдаг вэ? түүний мөн чанар юу болохыг ойлгуулахад чиглүүлнэ. Үүний тулд “Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн бус үйл ажиллагаа” сэдвээр мэтгэлцээн явуулах нь суурь ойлголтыг бататгах ба мэдээлэл цуглуулж боловсруулалт хийх арга зүйн материал, цахим үзүүлэнгүүдийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж болно. 		

ХҮНИЙ ЭРХ БА ХУУЛЬ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
9.4.а Хүний эрхийн төрөл, хэлбэр, ангиллыг судлан, иргэний болон улс төрийн эрх ардчиллын үнэт зүйлс болох талаар үндэслэл дэвшүүлэх	<ul style="list-style-type: none"> - Иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын эрхийн талаар тайлбарлана. - Ардчилал, шударга ёсны үндсэн баталгаа нь иргэний эрх, улс төрийн эрх, эдийн засгийн эрх, нийгэм, соёлын эрх болохыг жишээ баримтад үндэслэн нотолгоо гаргана. 	
9.4б. Иргэн эрхээ эдлэх, үүрэг, хариуцлагаа биелүүлэх нь зайлшгүй болохыг жишээ, тохиолдол шинжлэн, тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн амьдралыг зохицуулж байгаа эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээ, нийгмийн гишүүдийн эрхэмлэдэг үнэт зүйлсэд харшлахгүйгээр нийгмийн харилцаанд нийцтэйгээр оролцохын ач холбогдлын талаар асуудал дэвшүүлнэ - Тухайн асуудлын талаар өөрсдийн санал бодлоо илэрхийлнэ. - Жишээ тохиолдол шинжлэх замаар эрх, үүрэг, хариуцлагаа биелүүлэх нь хамгийн сайн шийдэл болохыг батална. 	Нэмэхжаргал.Т ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ., Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VI-IX . Багшийн ном УБ.,
9.4в. Хуулиар хүний эрхийг хамгаалдаг болох үндэслэлийг нэрлэж, эрхээ	<ul style="list-style-type: none"> - Хүний эрхийг хангаж хамгаалахад төрийн хүлээх үүргийг тайлбарлана. - Монгол улсын иргэний хүлээх үүргийн талаар мэдээлэл цуглуулна. 	

хамгаалах, зөрчигдсэн эрхээ сэргээхийн тулд ямар үйлдэл хийх хувилбаруудыг дэвшүүлэх	- Жишээ тохиодол шинжлэн ямар эрх зөрчигдсэн, эрхийг хэрхэн сэргээж болох талаар өөрийн хувилбарыг дэвшүүлнэ.	
Багшид зөвлөмж: <ul style="list-style-type: none"> • Хүний эрхийн төрөл, хэлбэр, ангиллын талаарх ойлголтыг сурах бичиг дэх агуулгаас тохиолдол шинжлэх явцдаа өөрсдөөр нь судлуулхад анхаарна. • Сурах бичиг дэх хүний эрхийн үндсэн зарчмуудын талаарх мэдээллийг ашиглана. • Монгол улсын Үндсэн хууль, 2-р бүлгийг ашиглана. • Нэг тохиолдлын хүрээнд бүлгээр нь хичээлийг төлөвлөн судлахдаа үндсэн ойлголтуудыг эзэмшихэд суралцахуйг хөтлөөрэй. • Сурагчдын үйл ажиллагааг ардчиллын үнэт зүйлсийн хэм хэмжээний хүрээнд зөв чиглүүлээрэй. 		

НИЙТИЙН УДИРДЛАГА

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
9.5а. УИХ, Засгийн, Шүүхийн байгууллагын эрх хэмжээ, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлог, уялдаа холбоог судлан, засаглал хуваарилалтын талаар ойлголтой болох	<ul style="list-style-type: none"> - УИХ, Засгийн, Шүүхийн байгууллагын эрх хэмжээ, гүйцэтгэх үүргийн талаар хэлэлцэнэ. - Тэдгээр байгууллагын гүйцэтгэх ажлын талаар мэдээлэл цуглуулна. - Эрх мэдэл хуваарилалтын талаарх өөрийн ойлголтоо тайлбарлана. 	Нэмэхжаргал.Т ба бусад (2017) Нийгэм судлал-VII анги. Сурах бичиг УБ., Түмэндэлгэр. С ба бусад (2015) Нийгмийн ухаан VI-IX . Багшийн ном УБ.,
9.5б. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжуудыг судалж, оролцох шаардлагын үндэслэл дэвшүүлэх	<ul style="list-style-type: none"> - Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг нэрлэнэ. - Иргэдийн оролцох боломжуудын арга, аргачлалыг бичнэ. 	
9.5в. Улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн ялгааг харьцуулан судалж, ардчилалд иргэдийн оролцоо ямар ач холбогдолтойг тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Ардчилсан болон ардчилсан бус дэглэм дэх иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн талаарх жишээ, тохиолдлыг харьцуулан шинжилж, ялгааг гаргана. - Ардчилсан дэглэмийн үед иргэдийн оролцоо чухал ач холбогдолтой болохыг тодорхойлж, оролцооны хэлбэрүүдийг нэрлэн, эрэмблэнэ. 	
Багшид зөвлөмж: <ul style="list-style-type: none"> • Хичээлээр судлах үндсэн ойлголтуудыг багцлан судлахад төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлнэ үү. • УИХ, Засгийн Газрын тогтоол зэргийг оновчтой сонгож ашиглахдаа сонгосон шийдвэр нь энгийн ойлгомжтой, хүүхдүүдийн эрх ашигтай шууд холбоотой байхыг чухалчилна уу. • Багш шүүхийн үйл ажиллагааг зохион байгуулах сурагчидтай урьдчилан ярилцаж мэдээлэл өгсөн байна. Аль болох бүх хүүхдүүдийг өөр өөрийн үүрэгтэй оролцуулах, мэргэжлийн хүнээр шүүх хурлыг удирдан зохион байгуулвал илүү тохиромжтой. • 9.5в. суралцахуйн зорилтын хувьд: Хувь хүмүүсийн үзэл бодол, байр суурийн ялгаатай байдал онцлогийг илэрхийлсэн тохиолдлууд нь гэр бүл, найз нөхөд, хамт олон, орон нутгийн болон нийгмийн институтын хүрээнд үзэл бодлын ялгаатай байдлыг илтгэн харуулсан байхад анхаарна. Зорилго нь сурагчид тэдгээр ялгаатай байдалд хэрхэн хандаж байгааг тодорхойлж, хэрхэн хүндэтгэлтэй хандах талаар ойлгуулахад чиглэнэ. • Сурагчдыг сэдэлжүүлэх, хамтран ярилцах зэрэгт чиглэсэн тайлбар бүхий зурагт үзүүлэн, 		

бичлэг, ярилцлагын тэмдэглэл, эрх зүйн баримт бичиг, хуулийн холбогдох заалт, түүхэн баримт мэдээлэл зэргийг ашиглаарай.